



“МОНБИЙФ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2023 он 03 сар 01 өдөр

Дугаар 4


Улаанбаатар хот

Компанийн гүйцэтгэх захирлыг өөрчлөх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.33.7 дах хэсэг болон ажилтны гаргасан хүсэлтийг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Монбийф” ХК-ийн Гүйцэтгэх захирал Сүрэндулам овогтой Сайнбилэгтийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, тус компанийн Гүйцэтгэх захирлаар 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс Цагаач овогтой Оюунсүрэнг томилсугай.
2. “Монбийф” ХК-ийн нэрийн өмнөөс хууль, тогтоомж болон компанийн дүрэм, гэрээ, хэлцэл байгуулах, харилцагч банкны гүйлгээ хийхэд гарын үсэг зурах зэргээр итгэмжлэлгүйгээр компанийг төлөөлөх, компанийн эрх ашигт нийцэх албан бичиг баримтад компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ц.Оюунсүрэн/-д үүгээр олгосугай.
3. Гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-ийг үүрэгт ажлаас нь чөлөөлсөнтэй холбогдуулан хариуцан ажиллаж байсан ажил үүргийг шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал /Ц.Оюунсүрэн/-д зохих журмын дагуу хүлээлгэн өгөхийг /С.Сайнбилэгт/-д үүрэг болгосугай.
4. С.Сайнбилэгттэй ээлжийн амралт болон бусад эд хөрөнгийн тооцоог хийх, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилт хийхийг Ерөнхий нягтлан бодогч /Б.Ганболор/, Хүний нөөцийн менежер /Б.Тамир/ нарт тус тус даалгасугай.
5. Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал /Ц.Оюунсүрэн/-тэй менежментийн гэрээг байгуулж ажлын байрны тодорхойлолтыг танилцуулахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /Б.Тамир/-д даалгасугай.
6. Гүйцэтгэх захирал /Ц.Оюунсүрэн/-д Менежментийн гэрээнд заасан цалин, урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Ганболор/-д зөвшөөрсүгэй.
7. Компанийн гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн бүртгэлийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлэх, гэрчилгээг хүлээн авах, шаардлагатай баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Хуулийн ахлах зөвлөх Түмэнжаргал овогтой Солонго /РД:ХВ83101062/-д итгэмжлэн олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ж.БАРСБОЛД